

**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН
БАЙДЛЫН СУДАЛГАА**

ДХИС-ийн магистрант, хошууч А.Тавхайдорж

Хураангуй: Архангай аймгийн нутаг дэвсгэрт 2012-2021 онд тохиолдсон гамшиг осол, аюулт үзэгдлийн улмаас учирсан нийгэм, эдийн засгийн хохирлыг тооцоолон, гамшиг ослын тохиолдлууд, аймгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зорилгоор бичиглэл судалгааг хийсэн.

Судалгааны ажил нь Архангай аймагт бүртгэгдсэн гамшиг ослын тоо мэдээг Онцгой байдлын газрын тайлан, гамшгийн мэдээний нэгтгэл, шуурхай удирдлагын зарлан мэдээлэх төвд бүртгэгдсэн хоногийн мэдээ, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн акт, дүгнэлтээс нэгтгэн авч гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн хамралтыг тооцоолж үр дүнг нэгтгэн гаргасан.

Түлхүүр үгс: Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл, гал түймэр, усны осол, гамшгийн эрсдэл.

Архангай аймгийн танилцуулга

Аймгийн товч танилцуулга: Архангай аймаг 1923 онд байгуулагдсан. 19 сум, 101 багтай, Монгол Улсын төв хэсэгт Баянхонгор, Хөвсгөл, Завхан, Булган, Өвөрхангай аймгуудтай хил залган Хангайн бүсэд оршдог. Өндөр уул, ой, тал хээр хосолсон 55.3 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, 94.205 мянган хүн ам, 27.0 сая толгой малтай, Монгол улсын аялал жуулчлалын байр зүй сайтай нийгэм эдийн засгийн хувьд олон онцлог шинж чанартай аймаг юм⁷².

Аймгийн бүх нутаг далайн түвшнээс 1200-3600м өндөрт өргөгдсөн Хангайн нурууны салбар уулс, мөн ойт хээр, тал хээрийн бүсээс бүрдэнэ.

Аймгийн бүх нутгийн 70.7 хувийг малын бэлчээр, 1.8 хувийг хадлангийн талбай, 0,6 хувийг тариалангийн талбай, 15.7 хувийг ой мод тус тус эзэлдэг. Энд хуш, гацуур, хар мод, хус, улиас, хайлаас, бургас зэрэг шилмүүст, навчит мод, буриагуул, боролзгоно, торлог, яргай, чаргай, яшиль, балгана, тавилгана, монос, шар мод, далан хайлс, жимст модод зэрэг 50 гаруй төрлийн модлог бут ургамал ургадаг.

Хангайн нуруунаас эх авсан хойт урд хоёр Тамир, Хануй, Хүнүй, Чулуут, Орхон, Суман, Мөрөн зэрэг олон гол мөрөн, Өгий, Холбоо, Дөрөө, Тэрхийн цагаан нуур, Хөх, Их, Хөдөө, Цайдам, Буйлан, Дуут нуур, Баян-Улаан зэрэг их бага нуур зэрэг томоохон гол, нууруудаас гадна Архангай аймгийн нутгаар 800 гаруй гол, горхи урсахдаа олон мянган га бэлчээр хадлан, тариалангийн талбайг усаар хангаж байдаг⁷³.

Сэдвийг сонгосон үндэслэл: Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй⁷⁴ гэж заасан учир гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь төрийн хамгийн чухал үүргийн нэг.

Байгалийн гамшиг, ган зуд, объектийн болон ой, хээрийн гал түймэр, олныг хамарсан хүн, мал амьтны гоц халдварт өвчин, усны осол, үерийн аюулт үзэгдэл, газар

⁷² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn 2021 он

⁷³ Arkhangai.khural.mn/n/101097

⁷⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг 16 дугаар зүйл 2 дахь заалт

хөдлөлт нь олон жилийн хөдөлмөрийн үр дүнг хэсэг хормын дотор сүйрүүлж, олон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг сүйрүүлж байна.

Архангай аймгийн хэмжээнд тохиолдсон гамшиг осол, аюулт үзэгдлийн сүүлийн 10 жилд тоон үзүүлэлтэд шинжилгээ хийж үзэхэд судалгааны эхний жил буюу 2012 онд гамшиг, аюулт үзэгдэл 78 удаа тохиолдож байсан бол судалгааны төгсгөл 2021 онд 123 болж өссөн үзүүлэлттэй байна. 10-н жилийн дундажаар 45 буюу 2012 оноос гамшиг, аюулт үзэгдлийн тоо 57.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Архангай аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа.

Архангай аймаг нь 2019 онд аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавхыг тооцон эрсдэлийг тодорхойлоход орон нутгийн 84.21% нь өртөх байдал ихтэй, эмзэг байдал нь аймгийн хэмжээнд маш их байна.

Архангай аймаг нь гамшгийн эрсдэлийн түвшингээр 47 оноогоор **Дунд** зэрэгт үнэлэгдсэн. Цаашид гамшиг ослын тоо, давтамж улам нэмэгдэх хандлагатай байна.⁷⁵

Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллага нь аймгийн төвийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа боловч сум, багт урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, ямар үр дүнд хүрч байгаа нь одоогоор тодорхой бус байна.

Орон нутаг дахь ард, иргэдэд болзошгүй гамшиг осол, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг орон нутгийн телевиз, фм радио, сумдын Засаг даргын тамгын газрын гадна байрлах лед дэлгэц, Онцгой байдлын газар, хэлтэс, ангиудын цахим хуудас, гарын авлага, тараах материал, сэрэмжлүүлэг яриа, самбаруудаар дамжуулан байрлуулж ашиглаж байгаа боловч орон нутаг дахь гамшиг осол, аюулт үзэгдлийн тоо буурахгүй байгаа нь энэ асуудалд анхаарал хандуулж, байгаль, цаг уур, нийгэм эдийн засгийн байдалд тулгуурлан иргэд, орон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгаа, эрт зарлан мэдээлэх тогтолцоог чанар хүртээмжтэй хийх үйл ажиллагаа тогтмолжуулах нь үндэслэл болно.

Сэдвийн судлагдсан байдал.

Монгол Улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагаа үүсч хөгжсөнөөс хойш хугацаанд иргэний хамгаалалтын болон гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, сургалтын асуудлын талаар 2004 онд П.Цэдэв “Монгол оронд гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, 2012 онд П.Дамдин “Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга замыг боловсронгуй болгох нь”, 2013 онд Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцооны өнөөгийн байдал, хөгжлийн хандлага сэдвээр докторын зэрэг хамгаалсан бөгөөд судалгаандаа гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хийгдэх бэлэн байдлыг төлөвлөх, сургалт дадлага явуулах талаар судалж боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийсэн байна.

Мөн 2017 онд шинжлэх ухааны доктор, профессор О.Үржин, доктор, профессор П.Цэдэв нар “Гамшгаас хамгаалах үндэс” (Мэргэжлийн анги, Сайн дурынхан, Ажилтан, албан хаагчид, Иргэдэд зориулав), “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” (Их, дээд сургууль, коллежийн оюутнуудад зориулав), 2020 онд доктор Д.Алтангэрэл, доктор профессор П.Даш, доктор, дэд профессор Д.Сэржмядаг, доктор П.Чимэдцэрэн нар “Гамшгаас хамгаалах бодлого, стратеги” гэх зэрэг номыг эмхтгэн гаргаж 2015 онд С.Амгалан “Гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох боломжийг

⁷⁵ Архангай аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа 2019 он

судлах нь”, Ө.Амармэнд “Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах боломж”, 2018 онд П.Ууганбаяр “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын зарим асуудал”, 2019 онд Г.Цогтсайхан орон нутгийн иргэдийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийг бууруулах нь” гэх судалгааны ажлууд хийгдсэн байна.

Судалгааны ажлын объект: Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.

Судалгааны ажлын хязгаарлалт: Архангай аймгийн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.

Судалгааны ажлын практик ач холбогдол: Орон нутгийн байгаль, цаг уур, нийгэм эдийн засгийн байдалд тулгуурлан иргэд, орон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгаа, эрт зарлан мэдээлэх тогтолцоог чанар хүртээмжэй хийх үйл ажиллагаа тогтмолжиж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ус цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх талаарх гамшгаас урьдчилан сэргийлэх менежментийн тогтолцоо төлөвшиж, тогтвортой хөгжлийг хангах нөхцөл бүрдэнэ.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны менежментийн асуудал Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны онцлог, мөн чанар

“Орон нутаг” гэх үг нь агуулгын хувьд “Тодорхой хил хязгаартай улсын газар нутаг гэж тайлбарласан бол хөдөө “Орон нутаг” гэх үг нь хот суурингүй аглаг хээр газар гэх утгийг илэрхийлдэг байна⁷⁶ иймд тухайн нутагт амьдарч байгаа иргэдэд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх менежментийг сайжруулах нь гол асуудал юм.

Улс оны хэмжээнд гамшгаас хамгаалах менежмент гэсэн нэр томъёо нь саяханаас өргөн хэрэглэгдэх болсон. Үүнтэй холбоотойгоор Онцгой байдлын байгууллага болон олон нийт төдийгүй мэргэжлийн хүмүүс, тэрчлэн энэ салбарын эрдэмтэн, судлаачид ч янз бүрээр тайлбарласан байдаг.

Гамшгийг эрдэмтэн судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээр нь судлан үздэгч өөрсдийн тайлбарлах тал нь үзэл бодлын хувьд маш зөрүүтэй биш олон янзын тодорхойлолт байдагч эдгээр нь нийтлэг юм.

Дээрх бүгдээс “Гамшиг нь хоёр ойлголт бол нэгд, гамшиг нь ямар нэгэн аюул тохиолдох, хоёрт түүний улмаас учирсан их хэмжээний хохирлыг арилгахад нийгмийн чадавхи хүрэхгүй байх нөхцлөөр гол төлөв тодорхойлогдоно⁷⁷. Өөрөөр хэлбэл аюулт үзэгдэл тохиолдох үед түүнд бидний амьдарч буй нийгэм өртөж их хэмжээний хохирол үүссэнээр тодорхойлогдоно.

Гамшгаас хамгаалах тухай хуульд 4 дүгээр зүйлийн 4.1.20 “Гамшгаас урьдчилан сэргийлэх” гэж аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг⁷⁸ хэлнэ гэж хуулийн нэр томъёонд орсон.

2011 онд “Гамшгаас хамгаалах талаарх төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь” сэдэвт үндэсний бага хурлаас “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалт хийх нь аюулгүй амьдралын үндэс мөн” гэдгийг үндэс болгон

⁷⁶ Н.Даш., “Монгол хэлний тайлбар толь” Уб., 2016., 923 дахь тал

⁷⁷ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, Уб., 2017, 13 дахь тал

⁷⁸ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт

“Маргаашийн аюулгүй байдлын төлөө өнөөдөр хамтдаа зүтгэцээ”⁷⁹ гэж олон нийтэд уриалсан нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг анхаарах том асуудлыг хөндсөн томоохон асуудал юм.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2015-2025 онд багтаан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийн зорилго нь “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх замаар эрсдэлийг бууруулахад оршино”⁸⁰ гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 335 дугаар тогтоороор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг батлуулж 3 үе шаттай хэрэгжүүлж байна.

Мөн “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн II дугаар үе шатыг улсын хэмжээнд 2021-2025 онд хэрэгжүүлэхээр Шадар Сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тушаараал баталсан. “Стратегийн төлөвлөгөөний I үе шатанд санхүү, хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт бүрэн хангагдаагүй 30, 70 хувьтай дүгнэгдсэн 4 арга хэмжээг”⁸¹ II дугаар үе шатны арга хэмжээнд төлөвлөсөн байна.

Дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөө нь I үе шатнаас үндэсний хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа эрчимжиж, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхи дээшилж, гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан бий болж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдэх онцлогтой төлөвлөгөө нь 4 тэргүүлэх чиглэл тодорхойлсон. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох
2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх
3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх.⁸²

Гэж заасан 9 зорилтын хүрээнд нийт 56 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулахад эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон жендэрийн талаарх асуудлыг тусгасан байна. Дээрх нийт арга хэмжээг 35 яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны байгууллага хариуцах болон хамтран хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аюулгүй дэлхий ертөнцийг бий болгоход байгалийн аюулын нөлөөллийг бууруулах болон урьдчилан сэргийлэх нь онцгой чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн Ёкохамагийн стратеги хэмээх гамшгаас хамгаалах стратеги батлан гарсан ч олон оронд тодорхой нэг гамшгийн хор уршгийг арилгах гэсэн утгаар хэрэгжсэн хэвээр байдаг⁸³.


⁷⁹ “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь” сэдэвт үндэсний бага хурал эмхэтгэл., Уб., 2011., 105 дахь тал

⁸⁰ “Гамшгаас эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх заалт

⁸¹ “Гамшгаас хамгаалах цагаан ном” Уб., 2021., 62 дахь тал

⁸² “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат /2015-2030 онд/ төлөвлөгөө., Уб., 2015.,

Орон нутгийн хувьд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тулгуур 3 арга хэмжээнд зохион байгуулсаар ирсэн. Үүнд



ГАМШГААС ХАМГААЛАХ АНГИЛЛЫН СУРГАЛТ:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д гамшгаас хамгаалах сургалтыг дараах аниллаар явуулна гэж заасан байдаг. Үүнд:

- ✓ Удирдах албан тушаалтны
- ✓ Онцгой байдлын байгууллагын
- ✓ Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн:
- ✓ Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны
- ✓ Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн
- ✓ Иргэний гэсэн 6 ангилал хамаардаг⁸⁴

Гамшгаас хамгаалах сургалтаар дамжуулан оролцогч талуудад мэдлэг чадвар олгох талаар өмнө дурьдсан тодорхой зорилго, зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа хэдий ч одоогоор явуулж байгаа сургалт нь тэдгээрт цэгцтэй мэдлэг, чадвар олгох, дадлага төлөвшүүлэх, зөв зан үйлийг хэвшүүлэхийн оронд аймгийн төвөөс бусад сум орон нутаг дахь иргэд, малчдад зөвхөн мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэхээс хэтрэхгүй байна.

Энэ нь гамшгаас хамгаалах сургалт тухайн газар нутаг, хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд нийцсэн цагт үр дүнгээ өгдөгтэй холбоотой юм.

Гамшгаас хамгаалах сургалтаар уг сургалтад хамрагдагсдыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны олон чиглэлээр сургаж дадлагажуулах хэрэгцээ байдаг. Үүнд:

- ✓ Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
- ✓ Төлөвлөлт
- ✓ Зохион байгуулалт
- ✓ Аврах ажил явуулах
- ✓ Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
- ✓ Цагийн байдлыг үнэлэх, яаралтай тусламж хүргэх
- ✓ Холбоо мэдээллээр хангах
- ✓ Хямралтай хүнд нөхцөл авах арга хэмжээ
- ✓ Нөөц, хангалт
- ✓ Сэргээх босгох арга хэмжээ

Гамшгаас хамгаалах сургалт нь гамшиг ба эрсдэл, тэдгээрээс хамгаалах талаарх мэдлэгийг оновчтой, үнэн зөв, үр дүнтэй хүргэхэд чиглэгдэнэ. Гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулахдаа тухайн зорилтот бүлэг буюу сургалтад хамрагдах зохих бүлгийн гамшгаас хамгаалах талаарх мэдлэг ур чадварыг нарийн тооцож үзэх хэрэгтэй.

Эндээс аж ахуй нэгж байгууллагын гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээ гэдэг нь байгууллага өөрийн нөхцөл байдалдаа тохируулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааг төлөвлөж,

⁸⁴ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 зүйл

хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшихтэй холбоотой хүсэл, шаардлага гэж ойлгогдож байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгаа:


Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны талаарх ойлголт,

Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны талаарх ойлголтыг авч үзэхээс өмнө сурталчилгаа гэдэг үгний тайлбарыг авч үзье.

Сурталчилгаа /Реклама буюу Advertising/ Латины resamare “хашгирах” гэсэн үгнээс гаралтай нэр томъёо. Орчин үед энэ тэр томъёог нэлээд өргөн утгаар буюу аливаа зүйлийг хэн нэгэнд сурталчлан таниулах гэсэн утгаар голлон хэрэглэж байна⁸⁵.

Цахим технологи хурдан хөгжиж байгаа өнөө үед гамшгаас урьдчилан сэргийлэх төрийн үйлчилгээг орон нутаг дахь иргэдэд хурдан хүртээмжтэй хүргэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад олон сувгаар дамжуулан хүргэх нь хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм.

Монгол орны хувьд 2002 оноос зар сурталчилгааны тухай хуулийг батлан гаргаж хэрэглэгдэж байна. Тухайн хуульд “Зар сурталчилгаа” гэж иргэн аж ахуй нэгж байгууллагаас бараа ажил үйлчилгээ, төсөл үйл ажиллагаа гэх зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн”⁸⁶ мэдээллийг гэж нэрлэсэн байна.



Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны түүхэн уламжлалыг 4 хэсэгт болгож авч үзсэн байна⁸⁷. Үүнд:

1-р үе гамшгаас хамгаалах уламжлалт зан үйлийн үе, 1200 он хүртэл

Энэ үе нь Монголчууд эрт дээр үеээс удаан хугацааны туршид байгаль орчноо хамгаалах үйлийг зан заншил, сүсэг бишрэл, уламжлалаар дамжуулан үр хойч үедээ үлгэр, домог, зүйр цэцэн үг, цээрлэх ёс, аман хэллэг гэх мэт ардын зан үйлээр дамжуулан уламжлан ирсэн.

2-р үе хууль цаазын зохицуулалтын үе 1200-1920-оод он

⁸⁵ <https://mn.wikipedia.org/wiki/>

⁸⁶ Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт

⁸⁷ М.Пүрэвжав, “Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг сайжруулах нь” судалгааны ажил, Уб., 2017., 8 дахь тал

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд байгалийг хамгаалах, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, ган, зуд, цасан шуурганаас ард иргэдийг хамгаалах нь Их эзэн чингэс хааны үеэс эхлэн төрийн бодлогын анхааралд авч Их засаг, Алтан хааны цаазын бичиг, Монгол-Ойрдын их хууль, Халх журам, зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг, Монгол Улсын Үндсэн хууль зэрэгт тусгалаа олсон уламжлалтай байна⁸⁸. Мөн Чингис хааны Их засаг хуульд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр тавигчдад хатуу шийтгэл ноогдуулж байсныг “гал алдах, түймэр гарваас гэр орноор нь цаазаар авсугай”⁸⁹ гэж заасан байна.

Энэ бүхэн нь байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах зорилгоор эрхэмсэг дээдэс, ард иргэдийн оролцоог хангаж үүрэг хариуцлагыг тодотгож өгсөн байна.

3-р үе: Иргэний хамгаалалтын үе, 1920-оод оноос 2003 он

Иргэний хамгаалалтын үйл ажиллагаа нь Монгол улсад 1990 оноос хойш нэг тогтолцооноос нөгөөд шилжсэнтэй холбоотойгоор өөрчлөгдөж зөвхөн дайсны довтолгоо, дайн байлдан гэх зүйлээс холдож байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, аюулт үзэгдэл тохиолдохоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгахад чиглэгдсэн.

Монгол Улс нь Нэгдсэн үндэсний байгууллагын байгалийн гамшгийг бууруулах үйл ажиллагаанд оролцсон нь гамшгаас хамгаалах үзэл баримтлалын хүрээнд чухал тооцогдох зүйл болсон.

4-р үе шат: Гамшгаас хамгаалах менежментийн үе, 2003 оноос одоог хүртэл

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар иргэний хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг хэлэлцээд гаргасан 2001 оны 01 дүгээр зөвлөмжид байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр “иргэний хамгаалалтын тухай” хуульд өөрчилөлт оруулсан.


Монгол Улсын засгийн газар үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийж 2003 онд иргэний хамгаалалтын шинэчлэлт хийж 2005 онд Монгол Улсын гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх нь үндэсний бага хурлыг зохион байгуулсан.

2003 онд гамшгаас хамгаалах тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулж 2004 онд гурван чиг үүрэг бүхий Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газрыг нэгтгэн Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулснаар гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо бүрдсэн гэж үздэг.

Цахим сурталчилгааны давуу талууд:

⁸⁸ П.Цэдэв, “Монгол Улсад гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал” боловсролын ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Уб., 2004, 24 дэх тал

⁸⁹ Х.Нямбуу, “Их засаг хууль” 28 дугаар зүйл



Сэтгүүл зүйн түүхэнд 50 сая хэрэглэгчтэй болохын тулд радио 38 жил, телевиз 13 жил зарцуулсан бол интернэт маш бага хугацаанд 4 жилийг зарцуулсан байна. Үүнээс үзэхэд онлайн сэтгүүл зүй гэх ойлголт бий болсон цагаас хурдтай хөгжиж сонин борлуулалтийг 50%, телевизийг 25%, сэтгүүлийг 15% -аар бууруулсан үзүүлэлт байдаг.

Дэлхий дахинд 2000 онд интернет хэрэглэгчдийн тоо 370 сая орчим байсан ба 2021 оны байдлаар 20 жилийн хугацаанд 4 тэрбум болтлоо өссөн байна. Гар утас, цахим орчны хэрэглээ нэмэгдэж түүний чанар улам сайжирсаар дуу дүрсний ялгарал, мэдээ мэдээллийг түргэн хугацаанд олж авч цаг хугацаа болон зардлыг хэмнэж байна.

Гамшгаас хамгаалах улсын хяналт:

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд салшгүй холбоотой зүйлийн нэг нь гамшгаас хамгаалах улсын хяналт юм. Гамшгаас хамгаалах хяналтын зорилго нь “Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулахад оршино”⁹⁰.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн нэн чухал арга хэмжээ юм. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина⁹¹ гэж заасан байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална⁹².

Орон нутаг, аж ахуй нэгж байгууллагын түвшинд гамшгаас хамгаалах хяналт нь холбогдох эрх зүйн баримт бичгийг таниулах, сурталчилах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэргээр зөвлөх чиг үүрэгтэй байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3¹ дүгээр зүйлийн 3^{1.1.1} “хяналт шалгалт” гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг⁹³ хэлнэ гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм”-ийг баталсан нь гамшгаас хамгаалах хяналтын удирдлага зохицуулалтын үндсэн бичиг баримт юм.

Энэхүү дүрмийн зорилго нь: Гамшгийн аюулаас хүний амь, нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, нормативийн баримт бичиг, дүрэм журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулахад оршино⁹⁴.

⁹⁰ Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, Уб, 2017, 102 тал

⁹¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт

⁹² Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт

⁹³ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3¹ дүгээр зүйлийн 3^{1.1.1} дэх заалт


⁹⁴ Засгийн газрын 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм” -ийн 1.1 заалт

Уг дүрэмд зааснаар гамшгаас хамгаалах улсын хяналтыг төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хэрэгжүүлэх юм.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын зохион байгуулалт

Гамшгаас хамгаалах улсын хяналтыг гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч (цаашид нийтэд нь “улсын хяналтын байцаагч” гэх) хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нарын шатлал



Улсын хяналтын байцаагч нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон энэхүү дүрэм, бусад холбогдох хууль, дүрэм, журам зааврыг мөрдлөг болгоно.


Улсын хяналтын байцаагч нь онцгой байдлын байгууллагын алба хаагч байх бөгөөд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахлах байцаагчид, ахлах байцаагч ерөнхий байцаагчид ажлаа хариуцан тайлагнана.

Улсын хяналтын ерөнхий байцаагч улсын хяналтын ахлах байцаагч, улсын хяналтын байцаагчид улсын байцаагчийн эрх олгож, цуцална.



Гамшгаас хамгаалах хяналт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт гэсэн төрлөөр хийнэ. Төлөвлөгөөт хяналт гэдэг нь хэзээ, хаана, ямар үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих асуудлыг урьдчилан тодорхойлж, үйл ажиллагаа төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхийг хэлнэ.

Жил бүр Онцгой байдлын байгууллага нь Монгол Улсын Шадар Сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, аймгийн Засаг дарга, Онцгой байдлын газрын дарга нарын баталсан удирдамжийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.



Үүнд: Монгол Улсын Шадар Сайдын баталсан 4, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан 4, орон нутгийн онцгой байдлын газрын дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчийн баталсан 1-2 удирдамж жилд нийт 8-10 удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах хяналтын баталгаажилт

Гамшгаас хамгаалах хяналт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой

хууль, тогтоомж, дүрэм, стандарт, эрх зүйн баримт бичгийг сурталчилах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх болон уг үйл ажиллагаанд байгаа дутагдал, алдааг илрүүлэх, засах, таслан зогсоход чиглэсэн олон төрлийн баримт бичгээр баталгаажна. Үүнд:

- ✓ Удирдамж
- ✓ Танилцуулага илтгэх хуудас, тэмдэглэл
- ✓ Хяналт шалгалт хийсэн тухай акт
- ✓ Заавал биелүүлэх албан шаардлага
- ✓ Мэдэгдэл
- ✓ Дүгнэлт
- ✓ Ажиллагаа зогсоох тогтоол
- ✓ Аюулт үзэгдэл, осол гарсан тухай акт
- ✓ Торгуулийн тасалбар, шийтгэврийн хуудас

Дээрх бичиг баримт нь ямар нөхцөлд үйлдэхийг тухайн явуулсан хяналт шалгалтын үр дүнг харгалзан гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч тогтоодог бөгөөд зөрчил дутагдлыг арилгах, үүссэн нөхцөл байдлыг тодорхойлох эрх зүйн бичиг баримт болно.

Архангай аймгийн 2012-2021 онд тохиолдсон
гамшиг осол, аюулт үзэгдэлийн статистик судалгаа

Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, осол		20 12	20 13	20 14	20 15	20 16	20 17	20 18	201 9	20 20	20 21	Н ий т
Гал түймэр	Ой, хээрийн түймэр	8	7	8	5	5	6	4	2	13	2	60
	Объектын түймэр	51	58	72	57	55	58	61	58	44	44	558
Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга	7	0	9	2	7	5	4	4	4	6	48
	Аадар бороо, үер	1	0	0	0	0	3	1	2	5	34	46
	Зуд	0	1	0	0	1	1	1	0	1	0	5
	Аянга	2	3	0	2	1	2	1	1	0	0	12
	Газар хөдлөлт	0	0	0	0	0	0	1	1	1	7	10
Хүн, малын халдварт өвчин	Kovid-19 цар тахал	0	0	0	0	0	0	0	0	1	1	2
	Галзуу	1	1	7	11	9	20	9	6	15	0	79
	Боом		5	1	1	0	1	1	0	0	0	9
	Хонины цэцэг	0	0	0	0	2	2	0	0	0	0	4

	Үхрийн хорт салст халуурал	1	1	0	0	2	0	0	0	0	0	4
	Цусан халдварт өвчин	0	0	1	0	0	0	1	0	0	0	2
	Шүлхий	0	0	0	0	0	0	16	0	1	10	27
Хүний үйл ажиллагаатай осол	Гол, нуурын усанд унаж осолдсон	5	1	5	6	4	7	8	4	2	7	49
	Химийн хорт болон аюултай бодисын алдагдал	0	2	0	0	0	0	0	0	0	0	2
	Зам тээврийн осол		5	1	2	1	1	6	1	1	4	22
	Уурхайн осол	0	0	0	0	0	1	0	0	0	0	1
	Эрэн хайх дуудлага	2	4	2	1	1	3	4	15	6	8	46
Нийт тоо		78	88	106	87	88	110	118	94	94	123	986
Гамшиг, аюулт үзэгдэл, осол	Аварсан хүн	68	75	84	94	103	148	126	96	154	236	1184
	Аварсан хөрөнгө /тэрбум/	0.7	0.1	0.7	1.2	2.2	1.5	1.8	1.4	4.5	2.5	16.6
	Учирсан хохирол /тэрбум/	5	0.3	0.7	2.6	18.8	1.5	3.7	1.3	13.3	3.5	50.7
	Амь насаа алдсан хүн	10	4	8	10	6	16	14	7	9	50	134
	Хорогдсон мал	43	29393	216	38	104871	104198	21038	714	71239	5391	337141


Архангай аймгийн гамшгаас урьдчилан сэргийлэх
нэгдсэн арга хэмжээний судалгаа

д/д	Зохион байгуулсан арга хэмжээ	2019 он	2020 он	2021 он	2022 он
-----	-------------------------------	---------	---------	---------	---------

		Тоо	хувь	Тоо	Хувь	Тоо	хувь	Тоо	хувь
1	Гамшгаас хамгаалах ангиллын сургалт	87	15%	70	15%	95	20%	147	30%
2	Аюул үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ	15	25%	15	25%	25	45%	47	78%
3	Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар сонин хэвлэлд мэдээ бэлтгэж тавих	31	40%	26	36%	79	100%	72	100%
4	Урьдчилан сэргийлэх ажлын талаар телевизэд өгсөн ярилцлага	40	70%	56	93%	189	100%	104	100%
5	Урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизээр шторк, сэрэмжлүүлэг явуулах	360	35%	550	50%	435	45%	935	86%
6	Иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа зохион байгуулах	72	32%	60	20%	160	55%	309	100%
7	Байгууллагын цахим сайт болон албаны сонинд мэдээлэл байршуулах	147	25%	533	74%	1144	100%	955	100%

95

Нэгдсэн судалгааг хувиар үзүүлвэл



1.2 ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Гадаад орнуудын гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны талаарх туршлагаас судлан үзвэл:

⁹⁵ Архангай аймгийн Онцгой байдлын газрын 2018-2022 оны нэгдсэн тайлан

Канад улсын туршлага

Канад улсын хувьд “Гамшиг”-ийн аюул нь эмзэг бүлгийнхэнтэй огтлолцоход үүсдэг нийгмийн үзэгдэл⁹⁶ юм гэж тайлбарласан байна.

Энэ нь хамт олны даван туулах чадвараас давсан буюу хэтрүүлж, аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй, хүмүүсийн өмч хөрөнгө, хүрээлэн буй орчин, байгалийн гаралтай үзэгдлээс үүдэлтэй байж болно.

Геофизик, биологийн орчинд эсвэл хүний үйлдэл, алдаанаас үүдэн хорлонтой эсвэл санамсаргүй байдлаар, технологийн доголдол, осол аваар, террорист ажиллагаа зэрэг орно.

Онцгой байдал: Хувь хүн, эд хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг шуурхай зохицуулах шаардлагатай одоо байгаа эсвэл удахгүй болох үйл явдал хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хамгаалах, эд хөрөнгө, байгаль орчинд учруулах хохирлыг хязгаарлах⁹⁷.

Аюул: Хүний амь нас, гэмтэл учруулж болзошгүй бие махбодийн үйл явдал, үзэгдэл, хүний үйл ажиллагаа, эд хөрөнгийн хохирол, нийгэм, эдийн засгийн хямрал, байгаль орчны доройтол.

СОРЕМ /SOREM/ ОНЦГОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

Онцгой байдлын асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтнууд. SOREM бол өндөр албан тушаалтнуудаас бүрдсэн хороо юм холбооны, муж, нутаг дэвсгэрийн засгийн газрыг төлөөлдөг онцгой байдлын менежментийг хариуцдаг.

Тус хороо нь санаачилгаар Канад улсад яаралтай тусламжийн менежментийг сайжруулах талаар заавар, зөвлөгөө өгдөг Онцгой байдлын удирдлагын дөрвөн бүрэлдэхүүн хэсэг болох урьдчилан сэргийлэх / эрдэлийг бууруулах, бэлэн байдал, хариу үйлдэл ба нөхөн сэргээх. Хорооны санаачлагыг янз бүрийн ажлын хэсэг, дэд ажлын хэсэг дэмжиж ажилладаг бүлгүүд.

Бүх үйл ажиллагаа, эрсдэлийн менежментийн арга хэмжээг багтаасан бүх аюулыг хамарсан онцгой байдлын менежмент урьдчилан сэргийлэх / эрсдэлийг бууруулах, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх гэсэн 4 багц хуваадаг.

Ихэнхдээ ийм холбоотой үйл ажиллагааны багц байдаг ба энийг Онцгой байдлын удирдлагын дөрвөн бүрэлдэхүүн хэсэг гэж нэрлэдэг. Онцгой байдлын менежмент нь хуваалцсан тогтвортой, чинээлэг, гамшигт тэсвэртэй нийгмийг бий болгох үүрэг хариуцлага юм.

Онцгой байдлын удирдлагын дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь:

1. Урьдчилан сэргийлэх / эрсдэлийн бууруулах: хүний амь нас, эд хөрөнгө, гамшигийн эрсдэлийг арилгах, бууруулах байгаль орчин, эдийн засгийн хямралыг багасгах. Урьдчилан сэргийлэх / эдийн засаг зарцуулах нь дэд бүтцийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг багтаана (жишээ нь, үерийн зам, далан барих) болон бүтцийн бус нөлөөллийг бууруулах арга хэмжээ (жишээлбэл, барилгын дүрэм, газар ашиглалт, төлөвлөлт, даатгалын урамшуулал). Урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээг бие даасан гэж үзэж болно.

2. Бэлэн байдал: Гамшигийн эсрэг хариу арга хэмжээ авч, түүний үр дагаврыг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дагуу зохицуулахад бэлэн байх үйл явдлын өмнө (жишээлбэл, яаралтай тусламжийн төлөвлөгөө, харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, нөөцийн тооллого болон сургалт, тоног төхөөрөмж, хөтөлбөр).

⁹⁶ Chemical, Biological, radiological, Nuclear and Explosives resilience strategy for Canada., 2011.,

3. Хариу арга хэмжээ: гамшгийн үед эсвэл гамшгийн өмнө эсвэл дараа нь түүний үр дагаврыг удирдан чиглүүлэх жишээлбэл яаралтай олон нийтийн холбоо, эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж, нүүлгэн шилжүүлэх гамшигтай холбоотой хохирол, хохирлыг багасгах.

4. Сэргээх: Гамшгийн дараа авсан арга хэмжээнүүдийн тусламжтайгаар нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл засах буюу сэргээх, Жишээ нь нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийг буцаах, гэмтлийн талаар зөвлөгөө өгөх, сэргээн босголт, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, санхүүгийн тусламж. Урт хугацааны тогтвортой сэргэлт, урьдчилан сэргийлэх хоёрын хооронд хүчтэй холбоо байдаг ирээдүйн гамшгийг бууруулах. Гамшгийн эрсдэлийг харгалзан сэргээн босгох ажлыг хийх ёстой гэж үздэг.

Нэг: Урьдчилан сэргийлэх /Эрсдэлийг бууруулах арга хэмжээг задлаж үзвэл/

Гамшгийн үндсэн шалтгаан:

- ✓ Байгалийн гамшиг
- ✓ Хүний гамшиг

Байгалийн гамшиг

- ✓ Бороо салхи, шуурга
- ✓ Үер
- ✓ Биологийн хүчин зүйлс
- ✓ Газар хөдлөлт
- ✓ Галт уулын дэлбэрэлт

Хүний гараар бүтсэн гамшиг

- ✓ Дайны болон терроризмын үйлдлүүд
- ✓ Гал түймэр
- ✓ Ус
- ✓ Дэлбэрэлт
- ✓ Барилгын дутагдал
- ✓ Цахилгааны доголдол

Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх боломжгүй ч хүндрэл магадлалыг арилгах, багасгах арга хэмжээ авч болно. Гамшиг олон хэлбэрээр тохиолдож болохоос үл хамааран бодит хохирол нь ихэвчлэн гал эсвэл уснаас үүдэлтэй гэж үздэг байна.

Хоёр: Бэлэн байдал

Байгалийн болон хүний гамшгийг даван туулахад бэлдэх:

- ✓ Бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөг бичгээр боловсруулах
- ✓ Төлөвлөгөөг шинэчлэх, туршиж үзэх
- ✓ Шаардлагатай тоног тнөхөөрөмжийг бэлтгэх
- ✓ Унтраалга, хавхлагуудын байршил бүхий барилгын давхрын төлөвлөгөөг багтаасан баримт бичгийг бэлтгэх хадгалах
- ✓ Бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн нэрс гэрийн хаяг, утасны дугаар, үүрэг хариуцлага жагсаалт
- ✓ ОБ хэрэгцээг санхүүжүүлэх зохицуулалт
- ✓ Даатгалын бодлогын хуулбар
- ✓ Аврах журам

Гурав: Хариу арга хэмжээ

Гамшиг тохиолдох үе

✓ Сэрүүлгийн дохио өгөх, ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх тогтоосон дүрэм журмыг мөрдөх

✓ Гамшгийн багийн ахлагчтай холбогдох, бэлтгэгдсэн аврах ажилтнуудыг удирдан чиглүүлж, товч мэдээлэл өгөх

✓ Урьдчилсан үнэлгээг хийх

✓ Орчныг тогтворжуулах

✓ Даатгалын зорилгоор гэмтсэн материалын зургийг авах, шаардлагатай материалыг бүртгэх, савлах, хатаах

Дөрөв: Сэргээн босгох

✓ Гамшгийн голомтод эвдэрсэн материалыг аль алиныг ашиглах боломжтой байдалд сэргээх хөтөлбөрийг бий болгох

✓ Сэргээн босголтын ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж, хамгийн сайн хувилбарын талаар зөвлөгөө авч, зардлын тооцоог гаргах

✓ Даатгагчидтай холбоо барих

✓ Гамшгийн голомтод цэвэрлэж нөхөн сэргээх

✓ Гамшгийн байдалд дүн шинжилгээ хийж, төлөвлөлтийг сайжруулах

Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгос улс нь сүүлийн 8 жилийн өмнөөс гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг социалаар зохион байгуулах болсон байна. Сурталчилгааг сургах болон зөвлөх хэлбэрээр явуулдаг бөгөөд сайн дурын идэвхитэн иргэдийг сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр бэлдэж мэдээллээр ханган иргэдэд зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласнаар нөлөөлөх нөлөөлөл нь нэмэгдсэн байна. Тухайн текст нь зөвлөсөн, анхааруулсан хэлбэрээр хийгдэж хүнд харагдахуйц 1 өгүүлбэрт багтаасан байна.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас Азийн орнуудад хэрэгжүүлж байгаа шилдэг туршлагаууд⁹⁸

Вьетнам улс

Гамшгийн менежментийн хувьд Засаг захиргааны бүтцэд дэмжлэг үзүүлж идэвхижүүлсэн ба тогтвортой гамшгийн менежмент /цогц арга хэмжээ энэ нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах/-ийг бий болгож чадсан. Тус улсад ихээхэн тохиолддог үер болон шуурганд өртөхүйц эмзэг байдлыг бууруулах

✓ Орон нутгийн аврах багийг байгуулж, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй болсон.

✓ 2583 гэр бүлийг амжиргааны өөр арга замд сургасан.

✓ 41 тосгоныг шуурга, үет тэсвэртэй бат бөх дэд бүтцийг барьж байгуулсан ба мөн хүчтэй үерийн үед нүүлгэн шилжүүлэх түр хоргодох байрыг бэлэн болгосон.

Гамшиг осол, аюулт үзэгдэл их тохиолддог орон нутагт эрсдэл ба нөөцийн зураглалын самбар байрлуулсан нь иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах талаар маш их мэдээллийг өгч байна.

Гамшгийн менежментийн залуучуудын бүлгүүд тодорхой хугацаанд Засаг захиргаанаас дэмжлэг авч зураглалыг шинэчилж орон нутагт өөр өөр газруудад байрлуулдаг.

Мөн орон нутгийн иргэдэд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулж үерээс хамгаалах даланг сайжруулан байгалийн зүй тогтолыг ашиглаж замын хажуугаар болон үерийн ойролцоох ууланд мод тарьж байна.

⁹⁸ “Олон нийгэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтын гарын авлага., 2013., 48 дахь тал

Индонез улс

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд орон нутагтаа эрт үеийн сэрэмжлүүлгийн системийг суурилуулж ашигладаг. Энэ нь орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудтай хамтран гамшигт өртөмтгий газруудад байрлуулдаг. /Урьдчилан сэргийлэх самбар/

Ирээдүй үеийнхэндээ аюулгүй хамгаалагдсан орчныг бий болгохын тулд сургуулиудад суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаануудыг улс даяр зохион байгуулж байна. Сургалтын системд өөрчилөлт оруулж эрсдэлийг тооцоолох, амьд гарах арга ухаанд сургаж, дадлагжуулаж байна⁹⁹.

Дүгнэлт:

1. Орон нутагт тохиолдож байгаа гамшиг осол, аюулт үзэгдлийн дүн мэдээнд тулгуурлан дүн шинжилгээ хийж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлийг зөв тодорхойлж үр дүнтэй зохион байгуулах нь хохирлыг бууруулах ач холбогдолтой.

2. Ухаалаг утас болон цахим орчин сүүлийн үед ихээхэн хөгжийн хирээр хүн нэг бүрийн өдөр тутмын хэрэглээ болсон энэ үед ухаалаг утас цахим хэрэглээг ашиглаж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь эдийн засгийн хувьд зардал багатай, үр өгөөжтэй байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ, 2017.
2. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх “Сэндай үйл ажиллагааны хүрээ” баримт бичиг, УБ, 2015.
3. Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр”
4. Монгол Улсын Засгийн газрын гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр
5. Архангай аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулсан тайлан, 2017-2021 оны жилийн тайлан, судалгаа. УБ.,
6. Үржин.О, Цэдэв.П., Гамшгаас хамгаалах үндэс., Уб, 2017, 15-19 дахь тал
7. “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтын гарын авлага. УБ хот,
8. Chemical, Biological, radiological, Nuclear and Explosives resilience strategy for Canada., 2011.,
9. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn 2021 он
10. Arkhangai.khural.mn/n/101097
11. Архангай аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа 2019 он
12. С.Амгалан “Гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судлах нь”,
13. Ө.Амармэнд “Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах боломж”,

⁹⁹ “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтын гарын авлага., Уб., 2013.,